

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Хот байгуулалт, барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2025/005/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Орхон аймаг

2025 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва

Утас: 70353088 Цахим хаяг: [purevlkhagvar@audit.gov.mn](mailto:purevlkhagvar@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Буян-ундрах

Утас: 70355805 Цахим хаяг: [Buyanundrakhb@audit.gov.mn](mailto:Buyanundrakhb@audit.gov.mn)

Аудитор: Г.Даваасүрэн

Утас: 70359826 Цахим хаяг: [davaasureng@audit.gov.mn](mailto:davaasureng@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



### ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2025.03.14 № 92  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ОРХОН АЙМГИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ,  
БАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН АЛБА  
ОНӨААТҮГ -ЫН ЗАХИРЛЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Ц.ХИШИГЖАРГАЛ ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Орхон аймгийн Хот байгуулалт, барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Орхон аймгийн Хот байгуулалт, барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Орхон аймгийн Хот байгуулалт, барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ нь тайлант хугацаанд орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа хөтөлбөр арга хэмжээний зураг төсөл зохиох, зохиогчийн хяналт, захиалагчийн төсөв зохиох ажил гүйцэтгэсэн хөлс 1,808.6 сая төгрөг, аж ахуйн нэгжийн захиалагчаар хэрэгжүүлсэн захиалагчийн хяналт хийсэн ажлын хөлс 37.0 сая төгрөг нийт 1,845.6 сая төгрөгийн орлого хүлээн авсан байна. Дээрх онцгойлсон асуудалтай холбоотой аудиторын дүгнэлт өөрчлөгдөөгүй болно.

#### Аудитын гол асуудал

Орхон аймгийн Хот байгуулалт, барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ -ын Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 6 дугаар тогтоолоор 2024 оны бизнес төлөвлөгөөнд нийт орлогыг 1,805.3 сая төгрөг, зардлыг 1,780.0 сая төгрөг, татварын дараах ашгийг 22.8 сая төгрөгөө тус тус баталжээ.

Гүйцэтгэлээр 1,891.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,807.08 сая төгрөгийн зардал гаргаж, 79.4 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Орхон аймгийн Хот байгуулалт, барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ-ын захирлыг Засаг даргын 2024 оны Б/20 дугаар захирамжаар 2024 оны 08 дугаар сарын 01-ээс чөлөөлж, байгууллагын ерөнхий инженер Ц.Хишигжаргалыг захирлын албан үүргийг түр орон гүйцэтгэгчээр томилсон байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдээс зүй бусаар нөлөөлөх нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

#### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	292,621,859.38	505,335,842.20
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	263,405,380.73	493,841,567.77
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	263,405,380.73	493,841,567.77
31210	Төгрөг	263,405,380.73	493,841,567.77
31213	Арилжааны банк дахь харилцах	263,405,380.73	493,841,567.77
33	АВЛАГА	20,743,892.65	908,348.43
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	20,743,892.65	908,348.43
35	БАРАА МАТЕРИАЛ	8,472,586.00	10,585,926.00
35100	Түүхий эд материал	0.00	0.00
35110	Тусгай зориулалттай материал	0.00	0.00
35400	Хангамжийн материал	6,488,176.00	8,601,516.00
35410	Бичиг хэргийн материал	1,984,410.00	1,984,410.00
35470	Бусад хангамжийн материал	0.00	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,771,189,740.49	3,247,261,245.56
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,771,189,740.49	3,247,261,245.56
39200	Биет хөрөнгө	269,601,729.51	342,383,605.10
39201	Барилга, байгууламж, орон сууц	17,231,943.77	17,231,944.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-5,776,098.60	-6,206,897.16
39203	Авто-тээврийн хэрэгсэл	49,850,000.00	108,850,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-28,099,500.00	-29,574,500.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	295,875,383.00	295,875,383.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-66,144,708.33	-107,707,486.60
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	41,408,243.00	41,408,243.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-34,743,533.33	-36,637,303.64
39300	Биет бус хөрөнгө	1,501,588,010.98	2,904,877,640.46
39301	Програм хангамж	16,385,000.00	16,385,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-8,554,100.02	-139,093,125.54
39303	Бусад биет бус хөрөнгө	1,493,757,111.00	3,027,585,766.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 1Н=1+Н</b>	<b>2,063,811,599.87</b>	<b>3,752,597,087.76</b>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	16,990,633.45	92,577,337.34
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	16,990,633.45	92,577,337.34
41300	Өглөг	16,990,633.45	92,577,337.34
41360	Бусад өглөг	16,990,633.45	75,000.00
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	16,990,633.45	92,502,337.34
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,046,820,966.42	3,660,019,750.42
51	Засгийн газрын хувь оролцоо	2,046,820,966.42	3,237,699,079.22
51101	Өмч /төрийн/ГГӨҮГ/	1,703,870,424.22	3,237,699,079.22
51200	Хуримтлагдсан үр дүн	341,995,079.43	421,365,208.43
51210	Өмнөх үеийн үр дүн	241,518,198.25	341,995,079.43
51220	Тайлант үеийн үр дүн	100,476,881.18	79,370,129.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	955,462.77	955,462.77
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН У1=1У+У</b>	<b>2,063,811,599.87</b>	<b>3,752,597,087.76</b>

### 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,129,331,275.11	1,692,671,457.27

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,129,331,275.11	1,692,671,457.27
120	Нийтлэг татварын бус орлого	1,129,331,275.11	1,692,671,457.27
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	550,500.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	550,500.00	0.00
120010	Борлуулалтын орлого (Цэвэр)	1,128,780,775.11	1,692,671,457.27
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,028,854,393.93	1,607,815,757.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,028,854,393.93	1,607,815,757.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,028,854,393.93	1,607,815,757.27
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,028,854,393.93	1,607,815,757.27
210810	Борлуулалт, маркетингийн зардал /ОНӨААТҮГ/	1,017,690,296.02	1,607,815,757.27
210814	Орлогын татварын зардал /ОНӨААТҮГ/	11,164,097.91	5,485,571.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (1П)=(1)-(П)	100,476,881.18	79,370,129.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (У1)=(Ш)+(1У)-(У)	100,476,881.18	79,370,129.00

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	1,078,116,863.00	955,462.77	253,002,735.45	1,332,075,061.22
10	2023 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	1,703,870,424.22	955,462.77	341,995,079.43	2,046,820,966.42
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,078,116,863.00	955,462.77	241,518,198.25	1,320,590,524.02
	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-11,484,537.20	-11,484,537.20
7	Өмчид гарсан өөрчилөлт	625,753,561.22	0.00	0.00	625,753,561.22
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00		0.00
9	Тайлант үеийн үр ДҮН	0.00	0.00	100,476,881.18	100,476,881.18
11	2024 оны 1-р сарын 1-нээрс үлдэгдэл	1,703,870,424.22	955,462.77	341,995,079.43	2,046,820,966.42
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,703,870,424.22	955,462.77	341,995,079.43	2,046,820,966.42
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	1,533,828,655.00	0.00	0.00	1,533,828,655.00
19	Тайлант үеийн үр ДҮН	0.00	0.00	79,370,129.00	79,370,129.00
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,237,699,079.22	955,462.77	421,365,208.43	3,660,019,750.42

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	840,084,780.93	1,886,309,276.00
1.1	Мөнгөн орлогын дүн	840,084,780.93	1,886,309,276.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	811,474,649.00	1,854,935,103.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	28,610,131.93	31,374,173.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	612,988,798.51	1,562,507,828.96

1.2.1	Ажиллагчдад төлсөн	415,815,626.00	760,578,567.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	106,537,324.47	204,765,053.35
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	61,115,375.02	29,983,880.00
1.2.4	Ашиглалтын зардал төлсөн	26,260,785.00	51,835,135.86
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	16,053,484.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	-	128,500,555.12
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-	1,905,120.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	3,259,688.02	368,886,033.63
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>227,095,982.42</b>	<b>323,801,447.04</b>
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>73,748,700.27</b>	<b>93,346,260.00</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	73,748,700.27	93,346,260.00
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(73,748,700.27)</b>	<b>(93,346,260.00)</b>
<b>4.1</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>153,347,281.75</b>	<b>230,455,187.04</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>110,058,098.98</b>	<b>263,405,380.73</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>263,405,380.73</b>	<b>493,841,567.77</b>

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт хэмнэлт	Хувиар
1	Борлуулалтын орлого	1,775,300.00	1,861,938.60	86,638.60	104.9
2	Бусад орлого	30,000.00	30,000.00	0.00	100.0
<b>3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны орлогын дүн</b>	<b>1,805,300.00</b>	<b>1,891,938.60</b>	86,638.60	104.8
4	Үндсэн цалин	997,274.01	891,877.70	105,396.31	89.4
5	Ажил олгогчийн НДШ төлөлт	124,659.30	111,484.71	13,174.59	89.4
6	Тэтгэмж урамшуулал	47,323.80	40,325.40	6,998.40	85.2
7	Ахмадын сан	3,000.00	1,600.00	1,400.00	53.3
8	Томилолтын зардал	19,880.00	19,880.00	0.00	100.0
9	Сургалтын зардал	21,475.00	15,640.50	5,834.50	72.8
10	Мэдээлэл, холбооны зардал	5,024.50	5,024.50	0.00	100.0
11	Даатгалын зардал, АТБӨЯХАТ	1,259.50	1,259.50	0.00	100.0
12	Бичиг хэргийн зардал	19,005.00	18,540.00	465.00	97.6
13	Засвар үйлчилгээ, багаж хэрэгслийн зардал	26,250.00	24,850.00	1,400.00	94.7
14	Барилга ашиглалтын зардал /ус, дулаан цахилгааны төлбөр/	10,236.17	10,236.17	0.00	100.0
15	Компютер, принтерийн сэлбэг хэрэгсэл үйлчилгээний зардал	27,439.90	14,939.90	12,500.00	54.4
16	ХАБЭА-н зардал	27,139.60	27,139.60	0.00	100.0
17	Түрээсийн зардал	53,088.00	43,292.40	9,795.60	81.5
18	Шатахууны зардал	30,307.60	13,800.00	16,507.60	45.5
19	Маркетингийн зардал	32,111.60	31,850.00	261.60	99.2
20	Гадны байгууллагатай хамтарсан арга хэмжээний зардал	86,970.00	81,262.60	5,707.40	93.4
21	Шинээр үндсэн хөрөнгө х/а	136,318.00	93,874.20	42,443.80	68.9
22	Авто сэлбэг засвар үйлчилгээ	9,234.00	9,234.00	0.00	100.0
23	Бусад мөнгөн зардал /дотоод үйл ажиллагааны зардал,/	30,500.00	20,721.50	9,778.50	67.9
24	Элэгдлийн зардал	36,664.40	204,670.50	-168,006.10	558.2

25	НӨАТ-н татвар	34,806.32	125,579.72	-90,773.40	360.8
	<b>ЗАРДЛЫН ДҮН /мян.төг/</b>	<b>1,779,966.70</b>	<b>1,807,082.90</b>		
	<b>АШИГ+, АЛДАГДАЛ -</b>				
	Татвар	25,333.30	84,855.70		
	Татвар	2,533.33	5,485.57		
	<b>ТАТВАРЫН ДАРААХ АШИГ, АЛДАГДАЛ /мян,төг/</b>	<b>22,799.97</b>	<b>79,370.13</b>		
	Ажилчдын тоо	28	26	-2.00	92.9

## **Гурав. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 29.1 сая төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 5.0 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 20.6 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 3.4 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

### **5.1 Төлбөрийн акт**

Хот байгуулалт, барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ-т ажилладаггүй 3 хүний Солонгос улсад зорчих онгоцны тийзийн үнэ 4.0 сая төгрөгийг байгууллагын данснаас төлсөн, багийн хамтын ажиллагааны төлбөр 1.0 сая төгрөгийн дэмжлэгийн шинжтэй, анхан шатны нотлох баримтын бүрдэлгүй зардлыг хувь хүний дансанд шилжүүлсэн зөрчлүүдэд 2 төлбөрийн акт тогтоов.

### **5.2 Албан шаардлага**

Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хөрөнгөөр 0.6 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан, байгууллагын бизнес төлөвлөгөөнд тусгаагүй, арга хэмжээний төлбөр 10.5 сая төгрөгийг зарцуулсан, гадаад албан томилолтын хуудас, удирдамж, томилолтоор явсан тухай тайлан зэрэг анхан шатны нотлох баримтгүйгээр байгууллагын дарга, хэсгийн дарга нарт 9.5 сая төгрөг олгосонд зөрчлийг давтан гаргахгүй байх талаар 3 албан шаардлага хүргүүлэв.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

#### **Илрүүлэлт: 1.**

Тайлант оны 1-12 дугаар саруудад тооцсон цалингаас нийгмийн даатгалын шимтгэлийг 3.4 сая төгрөгөөр зөрүүтэй суутгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.5-д "Нягтлан бодогчийн нэг орон тоотой аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байгаа нягтлан бодогч, эсхүл гэрээт нягтлан бодогч нь ерөнхий нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэнэ.", 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;", Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21.1-д "Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө." гэснийг хэрэгжүүлээгүй байна.

#### **Өгсөн зөвлөмж:**

Албан хаагчийн цалингаас нийгмийн даатгалын шимтгэлийг суутган тооцохдоо даатгуулагчийн шимтгэл төлөх хувийг сайтар тулгаж байх.

2. Дотоод хяналттай холбоотой

---

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт: 2.

Шинэчилгээ ТББ-тай хамтран ажиллах 20.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан бөгөөд хавсралтад заасан ажил бүрэн хийгдэж дуусаагүй, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй байхад гэрээний үнийг бүтэн шилжүүлсэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйл. “Захирлын эд хөрөнгийн эрх, үүрэг”, 1-д “Захирал дараахь эрх, үүрэгтэй:”, 3-д “Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах;”, Компанийн тухай хуулийн 83.1-т “Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна”, 95.4-т “Компанийн гүйцэтгэх удирдлага тухайн компанийн нягтлан бодох бүртгэл санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна” гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Удирдлагаас болон гэрээг хариуцан байгуулсан албан хаагч гэрээний биелэлтийг хянаж, гэрээнд заасан ажлыг хэрэгжүүлэх талаар байгууллагад шаардлага тавьж байх.

## Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	/сая төгрөгөөр/ Үүнээс											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орхон аймгийн Хот байгуулалт, барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ	7	29.1	2	5.0	3	20.6	2	3.4				
<b>Дүн</b>	<b>7</b>	<b>29.1</b>	<b>2</b>	<b>5.0</b>	<b>3</b>	<b>20.6</b>	<b>2</b>	<b>3.4</b>				

### Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Үүнээс: Аудит хийсэн хэлбэр				Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
		Аудитад хамрагдах	Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			